

ЧИНГИЙН ҮЕИЙН ХАЛХЫН ЦЭРГИЙН ТУХАЙ АСУУДАЛД

Л.Алтанзаяа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль. Түүх, Нийгмийн ухааны сургууль.

Өгүүллийн товч утга: Чингийн үеийн Халхын цэргийн түүхийн асуудалд холбогдох зарим мэдээнд тулгуурлан XVIII зууны үеийн аймаг хошууны цэргийн тооны өөрчлөлт, Их шавь нараас цэрэг гаргаж байсан тухай өгүүлэв.

Түлхүүр үг: Дөрвөн аймгийн бүгд цэргийн нийт данс, Их шавь нарын цэрэг, таван зүйлийн цэргийн тоо, Хутагтын Их хүрээний газраа суух цэргийг захиран суух хэргэмтэн.

Чингийн үеийн Халхын хошуу шавийн цэргийн тухай асуудал нь засаг захиргааны зохион байгуулалт, хошуу шавийн харилцааны түүхийн судалгааны чухал асуудлын нэг юм. XIX-XX зууны эхэн үеийн Халхын дөрвөн аймгийн цэргийн тухай баримт хэрэглэгдэхүүн нь нийтлэгдсэн(18) бөгөөд XVIII зууны Халх дахь цэргийн албаны талаар мэдээг тодотгууштай юм.

Тухайн үед хошуу сумны зэрэгцээ хутагтын шавь нар цэргийн албатай хэрхэн холбогдож байсан тухайд эрдэмтэн Ц.Сономдагва "Харин хуучин байсан Жавзандамба хутагтын шавь нар ардуудыг Жавзандамба хутагт ба түүний сүм хийдийн хурал номын зардал хэрэглэлийг нийлүүлэхээр хэвээр нь үлдээж, манжийн төрийн алба татвараас чөлөөлжээ"(1.93), эрдэмтэн Ш.Нацагдорж "Хутагт нарын шавь нь цэрэг, харуул, өртөөний зэрэг гол албанаас чөлөөлөгдөж өөр өөрийн харьяат хутагт нар, хүрээ хийд, хурал ном, бурхан тахил, шавийн ба орон нутгийн засаг захиргааны алба залгуулж байсан нь сум ардын залгуулж байсан алба татвараас арай хөнгөн байжээ"(2.51) хэмээсэн бол эрдэмтэн С.Пүрэвжав "Жавзандамба хутагтын шавь нар нь...цэргийн албанд үл дайчлагдах ба улсын хэмжээний төрийн албанаас чөлөөлөгдсөнийг эс тооцвол шавь нар нь эрх, үүрэг болон нийгмийн байдлаар хар феодалын хамжлага нараас төдий л ялгаварлагдах зүйлгүй..."(3.190) гэжээ. Мөн бусад зохиолд "Гэтэл ард олон Манжийн төрийн болон эзэн ноёдынхоо элдэв алба гувчуураас...шавийн харьяат болох зэргээр зайлсхийх болсноор лам болон шавь ардын тоо үлэмж нэмэгдсэн"(4.212) гэж бичжээ.

Энэ тухайд бид XVIII зууны үеийн Халхын хошуу шавийн цэргийн тухай асуудалд холбогдох зарим мэдээг харьцуулан нягтлахаар оролдлоо.

Монгол Улсын Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй "Дөрвөн аймгийн бүгд цэргийн нийт данс"-д(5) тэмдэглэснээр цэргийн тоог дараах байдлаар тэмдэглэжээ. Үүнд:

1. Энх-Амгалангийн 54-р он хонин жил мордсон цэрэг 2. Үүнээс дайнд орсон ба үгүйрсэн засгуудаас хассан цэрэг 3. Үүнийг гаргаад үлсэн алба үздэг цэрэг 4. Үүнээс Улиастайд суугаа цэрэг 5. Харуулд суудаг цэрэг 6. Харуулын өртөөнд суудаг цэрэг 7. Орхонд суудаг цэрэг 8. Боловсроход морддог цэрэг 9. Их хүрээнд суудаг цэрэг зэрэг болно. Мөн "Үүний дотроос зэмсэг үзэхүй дор харуул ба харуулын өртөөний цэрэг, хүрээний цэргийг цэргийн тоон дор оруулдаггүй." гэсэн тэмдэглэл бий.

Цэргийн тоог Түшээт ханы аймгийн хошууд болон бусад аймаг тус бүрээр үзүүлбэл,

Хошуу болон аймаг	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX
Түшээт хан	241	1404	101	11	11	-	5	18	2
Жанжин ван засагтай	1020	-	1020	101	106	19	42	286	17
Чин ван	506	120	386	38	40	7	21	36	8
Ван	481	-	481	48	51	9	21	107	8

Санзайдорж									
Ван Цэрэнбайдув	1300	200	1100	109	113	21	68	258	28
Бэйл Цэвдэн гүнтэй	100	-	100	9	2	0	2	14	1
Гүн Бампил	60	-	60	6	7	1	1	6	-
Гүн Мөнгө	360	-	360	36	38	7	16	107	6
Засаг Чивагжав	468	120	348	34	37	6	21	72	9
Засаг Лимпэлдорж	154	-	154	15	17	3	8	54	3
Засаг Ванжил	79	-	79	7	8	2	2	18	1
Засаг Дашпил	440	-	440	44	47	9	21	143	8
Засаг Цэрэнваншуг	600	-	600	60	63	11	27	179	11
Засаг Цэвдэн	100	-	100	10	10	2	5	36	2
Засаг Сүндэв	100	-	100	10	10	2	5	10	2
Засаг Сандувдорж	120	24	96	9	10	2	5	18	2
Засаг Ванбудорж	107	43	64	-	-	-	5	-	2
Аймгийн дүн	6236	647	5589	547	570	101	275	1362	110
Жанжин ван эфүгийн аймаг	3556	445	3111	306	317	56	144	748	58
Засагт ханы аймаг	2255	755	1500	147	153	27	81	356	34
Цэцэн ханы аймаг	-	-	-	-	-	-	500	534	98
Их шавь нар	-	-	-	-	-	-	-	-	200
Дөрвөн аймгийн дүн	12047	1847	10200	1000	1040	184	1000	3000	500

Уг дансанд "Энэ данснаас хойно зарим засгуудын цэрэг гагц нэг ташаа болж бяцхан шингээн солих болсон учир буй" гэсэн нь бий. Нэр дурдсан засаг ноёдын талаар тодруулбал,

Ван Санзайдорж нь 1736-1778 онд Халхын умар замын дундад дахь баруун этгээдийн хошуу (3 сумын албатай)-ны (15.35-37), ван Цэрэнбайтув нь 1740-1755 онд Халхын умар замын зүүн гарын дундад хошуун(14 сумын албатай)-ы (15.31-34), бэйл Цэвдэн нь 1706-1756 онд Халхын умар замын баруун гарын зүүн этгээдийн адгийн хошуу(1 сумны албатай)-ны(15. 38-40), гүн Бампил(дорж) нь Халхын умар замын зүүн гарын зүүн этгээдийн дундад алгийн хошуу(1 сумын албатай)-ны(15.41-43), гүн Мөнгө нь 1742-1762 онд Халхын умар замын зүүн гарын өмнөт хошуу(4 сумын албатай)-ны(15.64-66), засаг Чивагжав (Цэвэгжав)нь 1718-1762 онд Халхын умар замын дундад зүүн гарын адгийн хошуу(4 сумын албатай)-ны(15.28-30), Засаг Лимпэлдорж нь 1737-1758 онд

Халхын умарт замын баруун гарын баруун этгээдийн хошуу(1 сумын албатай)-ны (15.52-54), засаг Ванжил нь 1726-1750 онд Халхын умар замын баруун этгээдийн адгийн хошуу(1 хагас сумын албатай)-ны(15.55-57), Засаг Дашпил нь 1728-1777 онд Халхын умар замын зүүн гарын умарт хошуу(4 сумын албатай)-ны (15.25-26), засаг Цэрэнваншуг(Цэрэнванчиг) нь 1715-1756 онд Халхын умар замын зүүн гарын баруун этгээдийн адгийн хошуу(5 сумын албатай)-ны(15.44-46), засаг Цэвдэн нь 1732-1766 онд Халхын хойт замын дундад хошуу(1 сумын албатай)-ны (15.58-60), засаг Сүндэв нь 1732-1757 онд Халхын умарт замын зүүн гарын дундад зүүн этгээдийн хошуу(1 сумын албатай)-ны (15.49-51), засаг Сандувдорж(Сандивдорж) нь 1737-1780 онд Халхын хойт замын дундад баруун этгээдийн адгийн хошуу(1 сумыг албатай)-ны (15.68-69) засаг ноён байжээ.

Бид энэхүү мэдээнээс Халхын дөрвөн аймаг болон Түшээт ханы хошуу, Их шавь нарын цэргийн тоог болон дараах зүйлийг тодорхой үзэж болох байна. Тухайлбал, уг дансыг бичих үед Халхын Түшээт ханы аймгийн 17 хошуунаас цэрэг татаж байжээ. Энэхүү дансанд гарч буй засаг ноёдын нэрсээс үзэхэд уг данс 1742 оноос хойш бичигдсэн бөгөөд 1715 оны мэдээг хамт тэмдэглэжээ.

Түүнчлэн Халхын аймгуудаас 300, Их шавь нараас 200 цэрэг гаргаж Их хүрээнд суулгаж байсан тул тухайн үед Жавзандамба хутагтын Их шавь нар Манжийн төрийн цэргийн алба хааж Их Хүрээнд сууж байсан нь тодорхой байна. Энэ тухай бусад баримтад ч дурдсан нь бий. Тухайлбал, "Найралт төвийн өсдүгээр он. Зүүнгарын өөлд цэрэглэн ирж халхчуудыг түйвээсэн тухайд зарлигаар Жавзандамба ламыг Долоннуурын газраа шилжүүлэн суулгасан. Урьд зарлигийг дагаж дөрвөн аймгаас гурван зуу, шавиас хоёр зуун цэрэг гаргаж засаг нэг түшмэл хоёрыг нэмэн гаргаж өөлдийг сэргийлэн Хүрээний газраа суулгасан"(6.23) гэжээ. Түүнчлэн Энх-Амгалангийн сүүлч үед Их шавь нараас суманд орж байсан тухай мэдээг өмнө дурдсан билээ (7.40). Иймд тэр үед Их шавь нараас хошууны цэргийн сум эрийн тоог гүйцээж болон албан ёсоор цэргийн албанд хамрагдаж байжээ.

Эрдэмтэн С.Ичинноров, Н.Банзрагч нар "Түшээт ханы хошуу, анхны хан Чахундоржийн үед 100 эрийн төдийхөн өрх эрийг авч үлдээд 1300 эрийг 9 сум зохиож 3 хошуу байгуулсан гэдэг. Үүнээс Түшээт ханы хошуу Манж Чин улсын хаанаас онцгой эрх олж ямар ч алба үүргийг улсын өмнө хүлээн гүйцэтгэх үгүй зөвхөн Түшээт хан болон түүний ач гуч хөвгүүд ойр төрлийн тайж нарт үйлчлэх үүрэгтэй байжээ. Энэ учир Манжийн ноёрхлын эхэн үе XVII-XVIII зууны турш Түшээт ханы хошуу "язгуурын сум албагүй" хэмээн бичиг баримтад дурьдагдаж цэрэг, өртөө, харуул, албан сүрэг маллах, тариа тарих зэргийн ажилд оролцож байгаагүй ажээ"(10.147-148) хэмээдэг. Бидний танилцуулсан баримтад Түшээт хан хэмээн цэргийн тоог тэмдэглэсний учрыг бусад баримтаар тодотгож болно.

"Тавдугаар оны зэвсэг үзүүлэх арын арван дөрвөн хошууны данс энэ" гэсэн гарчигтай дансанд тэмдэглэснээр 1740 онд Халхын Түшээт ханы аймгийн Түшээт ханы хошууны цэрэг 198 байснаас буутай цэрэг 60, Жанжин жүн вангийн хошууны цэрэг 361 (буутай нь 108), Чин ван эфү Түдэвдоржийн хошууны цэрэг 317 (буутай нь 95), Жүн ван Санзайдоржийн хошууны цэрэг 255 (буутай нь 77), хэбэй бэйл Цэвдэнгийн хошууны цэрэг 61 (буутай нь 18), гүн Ванбугийн хошууны цэрэг 160 (буутай нь 48), гүн Бахайгийн хошууны цэрэг 13 (буутай нь 4), гүн Бампилдоржийн хошууны цэрэг 38 (буутай нь 11), засаг Чавагжавын хошууны цэрэг 311 (буутай нь 93), засаг Лимпилдоржийн хошууны цэрэг 61 (буутай нь 18), засаг Ванжилын хошууны цэрэг 40 (буутай нь 12), засаг Дашпилийн хошууны цэрэг 181 (буутай нь 54), засаг Цэрэнваншугийн хошууны цэрэг 268 (буутай нь 81), засаг Сандувдоржийн хошууны цэрэг 78 (буутай нь 24) байсан бөгөөд бүгд түшмэд 94, цэрэг 2342-ийн дотор буутай 703, хүн бүр буу,саадаг, нум, сэлэм нэжгээд бөгөөд буу бүрд 50 харвах дарь, 50 сум, 5 алт бялттай, буугүй цэрэг хүн бүр жад, саадаг, нум, 10 сум, сэлэмтэй байв. Нийт 23

туг, 234 хиуртай байжээ (8). Дээр дурдсан 1715 оны цэргийн тоотой харьцуулахад 1740 он гэхэд Түшээт хан аймгийн зарим хошуудаас гаргах цэргийн тоо буурсан байна.

Мөн Сайн ноёны аймгийг "Жанжин ван эфүгийн аймаг" гэж тэмдэглэснийг Сайн ноёны аймаг байгуулсан 1725 оноос өмнөх үеийн байдлыг улам нягтлан судлууштай юм. Эрдэмтэн Б.Лааган "1695 он гэхэд Сайн ноёны хошуунаас салбарлан байгуулсан хошуудаас нийт 400 гаруй цэрэг татсан байна...1752 оноос эхлэн Улиастай, Орхон голд жил бүрийн намар сэргийлэн хамгаалах чиглэлээр 2000 гаруй цэргийг бэлтгэхийн хамт Сайн ноён аймгийн есөн хошууны цэргийг Тамирт цуглуулж сургууль хийлгэж байх болгожээ" (11.84) гэсэнтэй харьцуулан үзэхэд 1715 онд 3556 цэрэг гаргаж байсан нь 1695-1715 онд тэр үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зарим өөрчлөлт болсныг илтгэнэ.

Эрдэмтэн Ц.Насанбалжир "Манжийн Тэнгэрийн тэтгэсэн хаан нь баруун монголыг байлдан эзлэх явдалд онцгой анхаарлыг тавьж байв. Юуны урьд Зүүнгартай байлдахаар үлэмжхэн цэргийн хүчийг бэлтгэхийн тулд манж, хятад цэргийн дээр Халх, Хотгойд, Цахар, Барга цэргийг үлэмжхэн хэмжээгээр оролцуулахаар шийдвэрлэж байжээ. Энэхүү шийдвэрээ биелүүлэхээр 1752 онд зөвхөн умарт замын Түшээт хан аймгаас гурван мянга, Цэцэн хан аймгаас дөрвөн мянга, Засагт хан аймгаас нэг мянга, Сайн ноён аймгаас хоёр мянга, бүгд арван мянган цэрэг татжээ"(12.96) гэсэн нь дээрх мэдээтэй дүйж байна.

Тэнгэрийн тэтгэсний 24-р (1759) оны "Халхын Цэцэн ханы аймгийн нутаг дор бэлтгэж өнгө үзүүлсэн цэргийг нэмэн засаж хуваасан хуамин данс"-тай хамт буй "Таван зүйлийн цэргийн тоо ба засаг хэргэмтний тоо"-ны дансанд (9) 1.Хутагтын Их хүрээний газраа суудаг цэргийн тоо. 2. 5 түмэн цэрэг болгоход шинэ нэмж нутагт бэлтгэх цэргийн тоо 3. Жил бүрийн намар цэргийн газраа боловсрон суудаг цэргийн тоо. 4. Үүнээс хассан цэрэг. 5. Нэгэн жилээр халалцаж Орхоны газраа суудаг цэргийн тоо. 6. Нутаг газраа бэлтгэж жил бүр зэвсэг үзүүлдэг цэргийн тоог тэмдэглэжээ.

Цэргийн тоог Цэцэн ханы аймгийн хошууд болон бусад аймаг тус бүрээр үзүүлбэл,

Аймаг хошуу	I	II	III	IV	V	VI
Далай сэцэн хан	4	192	15	3	-	157
Жанжин гүн	2	240	-	-	38	211
Ван Дамцог	8	384	-	-	19	375
Ван Базарсад	2	192	-	-	1	51
Бэйл Ванжил	16	816	265	-	-	150
Хэбэй Далай бэйс	11	480	-	-	86	469
Бэйс Ванжил	8	384	-	-	19	375
Ахай да гүн	5	240	79	-	-	175
Түшээ гүн Жамц	3	149	-	-	17	98
Гүн Шампил	6	288	-	-	94	595
Гүн Гэлэгвампил	3	149	-	-	56	112
Засаг Гончог	3	149	99	2	-	117
Засаг Чингүн	3	120	-	-	25	130
Засаг Дондов	2	149	49	2	-	118
Засаг Сайжайринчин	2	91	32	1	-	79
Засаг Ванжал	3	91	-	-	18	98
Засаг Цэвээн	3	120	-	-	55	86
Засаг Даржаа	3	91	-	-	18	93
Засаг Гэлэюндэв	6	288	-	-	51	282
Засаг Шандорж	5	91	-	-	1	99
Засаг Болор	1	14	-	-	2	5

Аймгийн дүн	99	4718	539	-	500	3966
Түшээт хан	109	4772	1312	-	273	3397
Жанжин ван эфү	58	2232	798	-	143	1909
Засагт хан	34	1231	351	-	84	971
Дөрвөн аймгийн дүн	300	12953	3000	-	1000	10243

Сэцэн хан аймгийн VI үзүүлэлтийн хувьд хошууны цэргийн тоон дээр “Энэ зэвсэг үзүүлдэг цэргийг захирах засаг 4, туслагч 8, харц хэргэмтэн 79” буюу бүгд 91 хүний тоо нэмэгдэж 3966 болно.

Мөн “Харуулын овооны цэрэг-Түшээт хан-570, Жанжин ван эфү-317, Засагт хан-153, 4 аймгийн дүн -1040.

Улиастайн цэрэг- Түшээт хан-543, Жанжин ван эфү-324, Засагт хан-133, 4 аймгийн дүн -1000.

Өртөөний цэрэг- Түшээт хан-99, Жанжин ван эфү-57, Засагт хан-28, 4 аймгийн дүн -184.

Хутагтын Их хүрээний газраа суух цэргийг захиран суух хэргэмтэн жил бүрийн өвлийн 3 сард Цэцэн ханы аймгийн засаг 1, Жанжин ван эфүгийн аймгийн захирагч 1, Түшээт хан аймгийн занги 1, хаврын 3 сард Засагт ханы аймгийн засаг 1, Цэцэн хан аймгийн мэрин 1, Түшээт ханы залан 1, зуны 3 сард Түшээт ханы засаг 1, Засагт ханы захирагч 1, Эфүгийн занги 1, намрын 3 сард Жанжин ван эфүгийн засаг 1, Түшээт ханы мэрин 1, Цэцэн ханы залан 1, жил бүр энэ ёсоор халалцан явах хэмээн тогтоосон болой” гэжээ.

Нэр дурдагдаж буй засаг ноёдын талаар тодруулбал, Ван Дамцог (Дэмчиг) нь 1735-1780 онд Халхын дорно замын дундад дахь баруун этгээдийн хошуу (4 сумын албатай)-ны (15.94-96), ван Базарсад нь 1740-1780 онд Халхын дорно замын зүүн гарын дундад хошуу (2 сумын албатай)-ны (15.85-87), бэйл Ванжил нь 1694-1749 онд Халхын дорно замын баруун гарын дундад хошуу(8 сумын албатай)-ны (15.97-99), бэйс Ванжил нь 1732-1762 онд Халхын дорно замын дундад дахь адгийн хошуу (1 сумын албатай)-ны (15.88-89), Ахай да гүн нь Халхын дорно замын баруун гарын дундад баруун этгээдийн хошуу(1 бүтэн хагас сумын албатай)-ны (15.110), түшээ гүн Жамц нь 1733-1767 онд Халхын дорно замын зүүн гарын өмнөт хошуу(1 сумын албатай)-ны (15.107-109), гүн Шампил (Сампил) нь 1731-1744 онд Халхын дорно замын зүүн гарын умарт хошуу(2 бүтэн 1 хагас сумын албатай)-ны (15.113-115), гүн Гэлэгвампил нь 1714-1771 онд Халхын дорно замын дундад дахь умарт хошуу (1 бүтэн 1 хагас сумын албатай)-ны (15.91-92), засаг Сайжайринчин нь 1742-1756 (1760-1769) онд Халхын дорно замын баруун гарын дундад зүүн этгээдийн хошуу (1 сумын албатай)-ны (15.125-127), засаг Даржаа нь 1750-1780 онд Халхын дорно замын дундад дахь зүүн этгээдийн хошуу (2 сумын албатай)-ны (15.102-105), засаг Болор нь 1727-1750 онд Халхын дорно замын баруун гарын зүүн этгээдийн хошуу(хагас сумын албатай)-ны (15.131-133) засаг ноёд байжээ.

Иймд дээрх дансыг 1749-1750-иад оны үед бичигдсэн гэж таамаглаж болох юм. Энэхүү баримтад Их шавиас цэрэг татсан тухай тэмдэглэл үгүй бөгөөд Их хүрээнд суух Халхын 4 аймгийн цэргийн тоо хэвээр 300 байна. Халхын Жавзандамба хутагтын Их шавь нь 1710 онд 3786 өрх, ам 17000 (13.159) байснаа 1764 онд 8513 өрх, 61286 ам (14.91) болж хүн амын тооны хувьд 3.5 дахин нэмэгдсэн боловч цэргийн дансанд бүртгэхгүй болсон нь Их шавь нарын нийгмийн байдалд гарсан нэг гол өөрчлөлт юм. Зэмсэг үзэхэд

Хүрээний цэргийг цэргийн тоонд оруулдаггүй гэсэн боловч чухам яг хэдэн оноос Их шавь нараас цэрэгт татахыг зогсоосныг улам нягтлан судлуулжтай.

Сэцэн хан аймгийн цэргийн талаар эрдэмтэн Б.Өлзийсүрэн "Тус аймгийн цэргийн бүртгэлээс үзвэл Тэнгэрийн тэтгэсний 25-р (1760) оны өргөх бичигт: Харуулын цэрэгт 500, Тамирын газарт буй цэрэг 40, харуул цэрэг 1040, бүгд өртөөний цэрэг 728, морь адууны цэрэг 473 гэж дурдсанаа, Тэнгэрийн тэтгэсний гучин найман(1773) онд сум 40, их хондго 5, бага хондго 2, эр 428, тоот цэрэг 1655-ын дотроос Орос зүгт тавьсан харуул, түр суугаа 447, Халхын хорин өртөөнд суугаа цэрэг 62, Хиагт замын өртөөнд суугаа цэрэг 150, харуул дотор сэргийлэн суугаа цэрэг 200, авын хаяа харгалзан суугаа цэрэг 66, эдүгээ нутаг бэлтгэж байгаа цэрэг 700 болмуй хэмээжээ. Энэ хоёр тооноос үзэхэд арван хэдэн жилийн дотор цэргийн зохион байгуулалтад өөрчлөлт хийж, харуул өртөөний цэргийг нэлээд цөөлсөн бололтой байна"(16.154) гэжээ. Энд Хутагтын Их хүрээний газраа суудаг цэргийн тухай тэмдэглэсэнгүйг анхааруулжтай. Дашрамд дурдахад бидэнд олдсон мэдээгээр Бүрэн засагтийн 9-р он (1870) онд "Жавзандамба хутагтын хүрээ сүмийг сэргийлэн суулгах цэргүүдийн цэс" гаргажээ. Түүнд, Түшээт хан аймгаас Жавзандамба хутагтын хүрээ сүмийг сэргийлэн суулгасан чуулганы дарга чин ван Цэ-гийн хошууны цэрэг 3, гүн Чимиддоржийн хошууны цэрэг 3, засаг тайж Цэрэндондовын хошууны цэрэг 24 байснаас бүгд буутай байснаас гадна жад, сэлэмтэй цэргүүдийн 2 нь чин ван Цэ-гийн хошуу, 2 нь гүн Чимиддоржийн хошуу, 16 нь тайж Цэрэндондовын хошууных байв. "Эдгээр бүгд намнах цэрэг 30 дор хүн тутам саадаг, хоромсогийн зэрэг бүрэн зэвсэг олгож суулгажээ"(17) гэжээ.

"Гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг"-т "Аливаа нэгэн зуун тавин эрийг нэгэн сум болго. Эр төөлөх жил тохиолдох бүр харьяат хошууны эрийн тоог хянан бодож, хэрэв үржсэн нь олон болвоос сум нэмүүл. Эрийн тоо хорвоос даруй эр тооныг үзэж хасагтун...Монгол идэр эр жаран наснаас дорогш арван найман наснаас дээшийг нь цөм эр төөлөх цэсэн дор зохион оруул. Өвчтөнийг тайлан хас. Гурван эр дор нэгэн хуяг өмсгө. Аливаа цэрэг гарахын зэргийн хэрэг тохиолдвоос хоёр эрийг зарж гарга. Нэгэн эрийг гэр дор агуулагтун"(19.190) гэжээ. Энэ тухайд эрдэмтэн Ш.Нацагдорж "Манжийн сум бол эхэндээ 10, сүүлдээ 300-н эрээс бүрдэж байсан боловч манж нар монголд сумны зохион байгуулалтыг хийдээ түүнийг 150-эрээс бүрэлдүүлэхээр тогтоожээ. Ийнхүү монголын сум нь 150-эр (өрх)-ээс бүрэлдэх боловч хошууны сумны тоо нь харилцан адилгүй байжээ" (20.189) гэх буюу "150 эрийг нэг сум зохиож түүнээс 50 эрийг хуяг өмсөх цэрэг буюу жинхэнэ эр цэргийн албанд явахаар тогтоосон" (13.169) гэжээ.

Бидний жишин үзэж буй баримтын мэдээгээр XVIII зууны эхэн хагаст албан ёсны сумны эрийн тоонд хүрэхгүй цэрэгтэй байсан Халхын хошуудын хувьд сумны тоог нь цөөлөхгүй байсаар байсны учрыг нэг талаас Халхын аймаг хошуудын 1 сумны эрийн тоог 150 хүргэхгүйгээр суманд тооцдог байсан, эсвэл хошуудын сумны тоо нь хожим нэмэгдсэн гэдгээр тайлбарлаж болно. Гэтэл энэ талаар тодорхойлох шинэ баримт бидэнд олдоогүй тул уг асуудлыг Чингийн засаг захиргааны бодлого, улсын албатай холбон үзэж болох юм. Эрдэмтэн Ш.Нацагдоржийн бичсэнээр "Улсын албыг сумын эрийн тоонд онуулан хуваарилж байсан учраас "Аливаа албыг цөм хошуу хошууны сум эрийн олон цөөнийг бодож" хуваарилж байжээ. Гэвч албыг "малын чинээ хир"-ийг харгалзан "малын тоогоор алба" хуваарилж байсан. Манжийн хуулинд эрийн тоонд албыг хуваарилах боловч хэрэг дээрээ өрхөд ногдуулж байжээ" (20.216) гэсэн нь тодорхой үед хошуу сумны алба үзэх цэргийн тоо цөөрсөн ч сумны тоо хэвээр байж албан үзэх сум, хондого, эрийн тоогоор бодсон хуваарийг баримталсаар байсны (12.97;18.5-17, 59-60) нөгөө талыг илтгэнэ.

Дээр дурдсан хэдэн баримт мэдээнд тулгуурлан дараах саналыг дэвшүүлж болох байна. Үүнд :

1. XVIII зууны эхэн хагас үеийн Халхын Түшээт хан, Сэцэн хан аймгийн хошуудаас залгуулж байсан цэргийн албаны хувьд хошууны 1 сумны 150 эрийн тоотой тэр бүр тохирч байсангүй ажээ. Иймд Халх дахь хошуу сумны зохион байгуулалт нь цэргийн албанаас гадна бусад алба залгуулахтай хэрхэн уялдаж байсныг лавшруулан судлууштай юм.

2. 1740-өөд оны үе гэхэд Түшээт хан аймгийн зарим хошуудын алба үзэх цэргийн хувьд 1715 оныхоос нэлээд буурч, Халхын дөрвөн аймгийн хувьд ч алба үзэх цэргийн тоо нэмэгдээгүй ажээ.

3. XVIII зууны эхний хагаст Жавзандамба хутагтын Их шавиас 200 цэрэг гаргаж байсан бөгөөд 1750-иад оноос хойш Их Шавиас цэрэг гаргахгүй болж Халхын 4 аймгаас 300 цэрэг гаргаж Их хүрээнд суулгадгийг хэвээр үлдээжээ.

Чухамдаа XVIII зууны эхэн хагаст Халхын цэрэг нь зөвхөн хошуу сумны бус хошууны болон шавийн цэргийн шинжтэй байсан бөгөөд цаашид бусад баримтаар нягтлан судлах шаардлагатай юм .

Abstract: In fact, 150 men must go to military service from 1 sum() by law of Manchu Ching dynasty. But after the first half of the XVIII century number of soldier couldn't have been reach in 150, coming from banners of Khalkha's Tusheet khan and Setsen khan aimaks. So need to narrowly study on organization of banners in Khalkha how was relating to other services despite of military service. In 1740 diminished in soldiers number of Tusheet khan aimak's some banners from when they were in 1715. So number of Khalkha's soldier didn't increased in the 1715 to 1740. From the first half of the XVIII century, 200 soldiers were being taking from Ikh Shabies of Jabtsundamba khutugtu. But it canceled from the 1750 and 300 soldiers were being taking from Khalkha's 4 aimaks they have been in Ikh khuree. Before this reform soldiers also have been in Ikh Khuree. Actually, in the first half of Khalkha's soldier wasn't only shape of banners(sum) also it was shape of banners and shabies soldier.

Ном зүй

1. Ц.Сономдагва. Манжийн захиргаанд байсан үеийн ар монголын засаг захиргааны зохион байгуулалт (1691-1911).УБ.,1961.
2. Ш.Нацагдорж. Сум, хамжлага, шавь ард.УБ.,1972.
3. С.Пүрэвжав. Монгол дахь шарын шашны хураангуй түүх. УБ.,1978.
4. Монгол улсын түүх.IV боть.УБ.,2003
5. Үндэсний Төв Архив (ҮТА). Ф-М10. Т-3. ХН-2
6. ҮТА.Ф-М1. Т-1.ХН-3508,3567
7. Л.Алтанзаяа. Их шавийн зарим харьяатын гарлын тухай. //Монголын түүх, угсаатны судлалын зарим асуудалд. Эмхэтгэсэн Аюудайн Очир, Ока Хироки.Тохоку Их Сургууль.Зүүн хойд Ази судлалын төв. 2004
8. ҮТА.Ф-М10. Т-1.ХН-30
9. ҮТА.Ф-М32. Т-1.ХН-42
10. С.Ичинноров, Н.Банзрагч. Эрдэнэзуу хийд ба Түшээт ханы хошуу.УБ.,1999
11. Б.Лааган. Сайн ноён хан аймгийн түүхэн хураангуй. УБ.,1999
12. Ц.Насанбалжир. Ар монголоос Манж чин улсад залгуулж байсан алба. (1691-1911) УБ.,1964
13. Ш.Нацагдорж. Манжийн эрхшээлд байсан үеийн Халхын хураангуй түүх.УБ.,1963
14. Д.Цэдэв.Их шавь. УБ.,1964
15. Ц.Сономдагва. Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт (1691-1997). Нэмж засварласан Ч.Банзрагч, О.Батсайхан. УБ.,1998

16. Б. Өлзийсүрэн. Халхын Сэцэн хан аймгийн хураангуй түүх.Өндөрхаан. 1993.
17. УТА. Ф-М10. Т-1.ХН-2263
18. Дөрвөн аймгийн алба тэгшитгэсэн данс. (Ш.Нацагдорж, Ц.Насанбалжир нар хэвлэлд бэлтгэж, өмнөх үг бичив). УБ.,1962
19. Гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг. (Дээд) Найралт, Алтан-Оргил харгуулан тайлбарлав. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.1989
20. Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал.УБ.,1978